



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 42 (423)

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- *Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай*
- *Элчин сайдыг згүүлэн татах, томилох тухай*

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- *Монгол Улсын баруун бүсийн хөгжлийн хөтөлбөр*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2005 он



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ  
Долоо хоног тутмын

Улаанбаатар хот

2005 оны арваннэгдүгээр сарын 10

№42 (423)

## Гарчиг

### Нэг. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

995.	Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай	Дугаар 74	833
996.	В.С.Литвиненко, Ю.В.Лыков нарыг одон, медалиар шагнах тухай	Дугаар 75	837
997.	Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай	Дугаар 76	837
998.	Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай	Дугаар 77	837

### Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

999.	Зарим бүсийн хөгжлийн хөтөлбөр батлах тухай	Дугаар 202	838
------	---	------------	-----

### МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 10 дугаар сарын 27-ны өдөр

Дугаар 74

Улаанбаатар хот

#### Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай

Үйлдвэрлэл, үйлчилгээ, боловсрол, эрүүл мэнд, татвар, тээвэр, эрчим хүч, уул уурхай, хэвлэл мэдээлэл, цагдаа, онцгой байдал, тор захиргааны

болон төрийн бус байгууллагад олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж байгаа дор дурдсан хүмүүсийг одон, медалиар шагнасугай.

#### СҮХБААТАРЫН ОДОНГООР:

Догсомын Цэдэв - Улаанбаатар хотын Ардын Депутатуудын Хурлын гүйцэтгэх захиргааны дарга асан

#### ХОДОЛМӨРИЙН ГАВЪЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

1. Дуламын Дашринчен - Данбадаржайлин хийдийн хамба лам
2. Лувсанбалдангийн Доржлүрвэ - Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын авто баязын жолооч
3. Дашнямын Гонгор - Нийслэлийн Нийгмийн даатгалын газрын дарга

4. Ишигхүүгийн Энэбиш - Говь-Алтай аймгийн Чандмань сумын дунд сургуулийн багш
5. Гэндэндоржийн Янсанжав - Нийслэлийн үйлдвэрлэл, үйлчилгээний "Очсан төв" ХХК-ийн захирал

#### ЦЭРГИЙН ГАВЪЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

Наваансүрэнгийн Ганболд - Нийслэлийн Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа

#### "АЛТАН ГАДАС" ОДОНГООР:

1. Каусылгазын Анаргул - Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн тасгийн эрхлэгч

2. Цохиогийн Адъяасүрэн - Байгаль орчны сургалт судалгааны Эко Ази дээд сургуулийн захирал



3. Дангаагийн Баатаржав - Нийслэлийн Хан-Уул дүүргийн Газрын албаны дарга

4. Жамсранжавын Баатархүү - Монгол-Оросын хамтарсан уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн ерөнхий баяжуулагч

5. Гэндэнсамбуугийн Бадамбазар - Нийслэлийн Сүхбаатар дүүргийн ЗДТГ-ын зохион байгуулагч

6. Наваанжанцангийн Балжинням - Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 7 дугаар хорооны Засаг дарга

7. Дамдинсүрэнгийн Банди - Дорноговь аймгийн Улаанбадрах сумын 8 жилийн сургуулийн багш

8. Жамъянгийн Батбаяр - Үндэсний татварын ерөнхий газрын дэд дарга

9. Гомбосүрэнгийн Бат-Оронго - Нийслэлийн "Кан-Ази" ХХК-ийн менежер, "Эверест-2005" багийн удирдагч

10. Дагвын Баярсайхан - Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн ИТХТ-ийн дарга

11. Осорын Ганбаатар - "Эрдэнэтийн дулааны цахилгаан станц" ХК-ийн ерөнхий инженер

12. Дамдинсүрэнгийн Гүнсэнноров - Дорнод аймгийн Хөлөнбуйр сумын ЗДТГ-ын дарга

13. Маньдирын Даваасүрэн - Нийслэлийн "Ган хийц" ХК-ийн ерөнхий захирал

14. Гунгаарэнцэнгийн Дамдинсүрэн - Эрчим хүчний зохицуулах газрын зохицуулагч

15. Жигжжавын Дангаа - Нийслэлийн Сүхбаатар дүүргийн ИТХТ-ийн ажлын албаны дарга

16. Сундуйн Данзан - МУБИС-ийн багш

17. Дүгэрийн Дашхорлоо - Нийслэлийн Хан-Уул дүүргийн ЗДТГ-ын санхүү эдийн засаг, төрийн сангийн хэлтсийн дарга

18. Цэдэнгийн Долсүрэн - Говь-Алтай аймгийн Дэлгэр сумын хүн эмнэлгийн салбарын эрхлэгч, их эмч

19. Дамдинсүрэнгийн Дорж - Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын малчин

20. Сэрэнзагдавын Доржсумъяа - Нийслэлийн Баянзүрх дүүргийн ИТХ-ын ахлах зохион байгуулагч

21. Чулууны Дугуй - Нийслэлийн Баянгол дүүргийн 85 дугаар цэцэрлэгийн заах арга зүйч

22. Дарьсүрэнгийн Ёндонлэрэнлэй - НИК ХК-ийн Орхон аймаг дахь салбарын жолооч

23. Мөнхийн Жанлав - Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Ахмадын хорооны дарга

24. Чимэдбазарын Жаргал - Олон улсын Атомын энергийн агентлагт цөмийн зэвсэг үл

дэлгэрүүлэх гэрээний биелэлтийг хангах инспектор

25. Дамбын Лхагва - Хэнтий аймгийн нэгдсэн эмнэлгийн их эмч

26. Дашлэлжээгийн Лхагвадэмбэрэл - Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн мэргэжилтэн

27. Батмөнхийн Мижиддорж - Говь-Алтай аймаг дахь Говийн их дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны дарга

28. Сүрэнхүүгийн Мөнхдулам - Нийслэлийн Сүхбаатар дүүргийн ЗДТГ-ын санхүү эдийн засаг, төрийн сангийн хэлтсийн төсвийн мэргэжилтэн

29. Бүсжавын Намхайням - ШУТИС-ийн Эрчим хүчний инженерийн сургуулийн багийн профессор

30. Пунцагийн Нэргүй - Хэнтий аймгийн Хэрлэн сумын 4 дүгээр сургуулийн багш

31. Туурийн Отгонбаяр - Ховд аймгийн Жаргалант сумын 10 жилийн 1 дүгээр сургуулийн биеийн тамирын багш

32. Балжиннямын Очбадрах - Нийслэлийн "Бөөний худалдаа" ХК-ийн ерөнхий захирал

33. Пүрэвжавын Оюунсүрэн - ШУТИС-ийн харъяа "Эрдэнэт" үйлдвэрийн дэргэдэх Технологийн сургуулийн сургалтын албаны дарга

34. Халтарын Оюунцэцэг - Дундговь аймгийн "ТОМС" компанийн менежер

35. Эрдэнийн Пунцаг - Нийслэлийн Налайх дүүргийн 1 дүгээр хорооны өндөр настан, НААҮ-ний ахмад ажилтан

36. Дагвадоржийн Саруул - ШУТИС-ийн харъяа "Эрдэнэт" үйлдвэрийн дэргэдэх Технологийн сургуулийн сургалтын албаны ахлах инженер

37. Цэрэнгийн Сэвжид - Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын 10 жилийн 5 дугаар сургуулийн захирал

38. Хажигийн Сериожан - Баян-Өлгий аймгийн нэгдсэн эмнэлгийн чих, хамар хоолойн зөвлөх эмч

39. Бямбын Сугир - Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын ИТХТ-ийн дарга

40. Жүгдэрийн Сундуй - Нийслэлийн Налайх дүүргийн 2 дугаар хорооны иргэн, өндөр настан, ахмад тэзвэрчин

41. Ванчингийн Сүрэнхүү - Б а я н - Ө л г и й аймгийн 10 жилийн 2 дугаар дунд сургуулийн багш

42. Хоролын Төмөр - Нийслэлийн Чингэлтэй дүүргийн ИТХТ-ийн нарийн бичгийн дарга

43. Жамъянжавын Төмөрбаатар - МУИС-ийн Монгол хэл, соёлын сургуулийн ардын урлаг судлалын тэнхмийн эрхлэгч

44. Цэрэндоржийн Төмөрхуяг - Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 10 жилийн 3 дугаар сургуулийн хичээлийн эрхлэгч

45. Нямдаваагийн Туул - Улсын Клиникийн төв эмнэлгийн хоол боловсруулах эрхтэн судлалын тасгийн эрхлэгч

46. Цэндсүрэнгийн Түмэнгэрэл - Нийслэлийн "Гэр хорооллын барилгажилт" хоршооны дарга, Нийслэлийн ИТХ-ын төлөөлөгч

47. Галбадрахын Уртнасан - Говь-Алтай аймгийн Нэгдсэн эмнэлгийн төрөх тасгийн эх баригч

48. Бадарчийн Хүрэлбаатар - Дархан-Уул аймгийн "Шарын гол" ХК-ийн эксковаторын машинч

49. Донровын Цэрэнлхагва - Өвөрхангай аймгийн Хархорин сумын 10 жилийн 1 дүгээр сургуулийн газарзүйн багш

50. Долгорын Цэрэнмягмар - Завхан аймгийн Улиастай сумын ЗДТГ-ын дарга

51. Төмөрпүрэвийн Цэрэннадмид - Нийслэлийн Баянгол дүүргийн "Монгени" цогцолбор сургуулийн бага ангийн багш

52. Ядамын Цэрэнхүү - Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр сумын 10 жилийн сургуулийн багш

53. Жигмэдийн Энхжаргал - Нийслэлийн мэдээлэл, технологийн "Сансар кабель" ХХК-ийн захирал

54. Дүүдээгийн Энхзаяа - ЭМШУИС-ийн багш

55. Бадамсүрэнгийн Энхравдан - ЭНЭШ Төвийн бөөрний мэс заслын тасгийн тэргүүлэх зэргийн их эмч

56. Дулмаагийн Энхтуяа - Нийслэлийн Сүхбаатар дүүргийн ЗДТГ-ын Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга

57. Сосорбарамын Эрдэнэмаам - МУБИС-ийн орос хэл, утга зохиолын тэнхмийн эрхлэгч

## ЦЭРГИЙН ГАВЬЯАНЫ ОДОНГООР:

1. Цэвэрэнравдангийн Батсуурь - Нийслэлийн Сүхбаатар дүүргийн цагдаагийн хэлтсийн тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа

2. Дамбийжанцангийн Булган - Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн хэлтсийн тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа

3. Аюурын Жутъяа - Нийслэлийн Налайх дүүргийн Цагдаагийн хэлтсийн ахлах байцаагч, цагдаагийн хошууч

4. Чулуунбатын Нэргүй - Нийслэлийн Баянгол

дүүргийн Онцгой байдлын хэлтсийн дарга, тэргүүн ахмад

5. Долгорын Нямжав - Нийслэлийн Хан-Уул дүүргийн Цагдаагийн хэлтсийн тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа

6. Сандагийн Отгонбаатар - Нийслэлийн Хан-Уул дүүргийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа

7. Содномпилийн Пионер - Замын цагдаагийн газрын Сүхбаатар дүүрэг дэх Замын цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн хурандаа

## ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Загдын Адъяасүрэн - Дорнод аймгийн Хөлөнбуйр сумын ИТХТ-ийн дарга

2. Чүлтэмсамбуугийн Александр - Дархан-Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ компанийн Зүүнхараа дахь салбарын диспетчер

3. Аханы Алпеш - Баян-Өлгий аймгийн Ахмадын хорооны зохион байгуулагч

4. Буянжаргалын Ариунгэрэл - Нийслэлийн Хан-Уул дүүргийн ЗДТГ-ын бичиг хэргийн эрхлэгч

5. Лувсандагвын Баагуул - Дархан-Уул аймгийн "Дархан-Сэлэнгийн Цахилгаан түгээх сүлжээ" ХК-ийн засвар туршилт тохируулгын хэсгийн ашиглалт засварын монтер

6. Аюурын Баатар - Дархан-Уул аймгийн "Дарханы дулааны цахилгаан станц" ХК-ийн токарччин

7. Дүгэржавын Бадамдорж - МУИС-ийн Монгол хэл, соёлын сургуулийн захирал

8. Түмэндэмбэрэлийн Бадамжунай - Архангай аймгийн Эрдэнэбулган сумын 10 жилийн дунд сургуулийн багш

9. Цэвээний Батдэмбэрэл - Нийслэлийн Баянгол дүүргийн ЗДТГ-ын иргэний бүртгэлийн тасгийн дарга

10. Дундаагийн Батзориг - Нийслэлийн Хан-Уул дүүргийн ЗДТГ-ын ерөнхий нягтлан бодогч

11. Дарамбазарын Батсайхан - Нийслэлийн Баянгол дүүргийн Тохжилт компанийн захирал

12. Бадраагийн Батчулуун - Нийслэлийн Баянзүрх дүүргийн 13 дугаар хорооны Засаг дарга

13. Дагвадоржийн Бат-Эрдэнэ - Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын референт

14. Лувсандоржийн Бибиш - Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын хүн эмнэлгийн сувилагч

15. Цээлээнэмжилын Гантөмөр - Нийслэлийн Хан-Уул дүүргийн 4 дүгээр хорооны Засаг дарга



16. Жамбажамцын Ганчулуун - Булган аймгийн Хутаг-Өндөр сумын 10 жилийн дунд сургуулийн багш
17. Хандхүүгийн Гэлэгбуу - ЭМШУИС-ийн харьяа Говь-Алтай аймаг дахь Анагаах ухааны коллежийн сургалт эрдэм шинжилгээ эрхэлсэн дэд захирал
18. Чойжилдоржийн Даваа - Нийслэлийн Хан-Уул дүүргийн ИТХ-ын ажлын албаны зохион байгуулагч
19. Дамдинсүрэнгийн Долгор - Булган аймгийн Тээвэр зохицуулалтын газрын жолооч
20. Намсрайн Дорждулам - Нийслэлийн Хан-Уул дүүргийн 14 дүгээр хорооны Засаг дарга
21. Цэвээний Жадамба - Хэнтий аймгийн Нэгдсэн эмнэлгийн эх баригч бага эмч
22. Шаниягийн Жалал - Баян-Өлгий аймгийн Алтанцэгц сумын өндөр настан
23. Цэрэнпилийн Жамъян - Дархан-Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ компанийн Зүүнхараа дахь салбарын жолооч
24. Лхагважавын Лхагваасүрэн - Дархан-Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ компанийн Зүүнхараа дахь салбарын диспетчер
25. Гэндэнгийн Ложоо - Говь-Алтай аймгийн Шарга сумын малчин
26. Мишигсүрэнгийн Мөнгөнцэцэг - Сүхбаатар аймгийн Аудитын газрын ахлах аудитор
27. Дэмбэрэлийн Мөнхдулам - Нийслэлийн "Цэцэрлэгжилт" компанийн цэцэгчин
28. Мятавын Мөнхцас - Нийслэлийн Баянгол дүүргийн Засаг даргын зөвлөх
29. Лодойн Мөнхцэцэг - Хууль зүй, дотоод хэргийн яамны ахлах мэргэжилтэн
30. Дамбадаржаагийн Нацагдорж - "Т е и н бусийн цахилгаан түгээх сүлжээ" ХК-ийн Дархан-Сэлэнгийн салбарын хэсгийн дарга
31. Навааны Нэргүй - Хэнтий аймгийн Нэгдсэн эмнэлгийн сувиллагч
32. Даваагийн Нямхүү - Нийслэлийн хувийн хэвшлийн "Улаанбаатар менежмент" ХХК-ийн Удирдах зөвлөлийн дарга
33. Нямаагийн Оргодол - Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын ахлах референт
34. Доржготовын Отгон - Нийслэлийн Баянзүрх дүүргийн 122 дугаар цэцэрлэгийн багш
35. Бадмаабаззрын Оюунцэцэг - Архангай аймгийн Эрдэнэбулган сумын 10 жилийн дунд сургуулийн багш
36. Пүрэвийн Оюунчулуу - Нийслэлийн Баянзүрх дүүргийн 10 жилийн 87 дугаар сургуулийн газарзүйн багш
37. Рагчаагийн Оюун-Эрдэнэ - Нийслэлийн Баянзүрх дүүргийн Тохижилт компанийн ажилтан
38. Чингисийн Өнөртүвшин - Нийслэлийн хэвлэл мэдээллийн "Төв цэг" сонин эрхлэгч
39. Цанжидын Сампил - Архангай аймгийн Эрдэнэбулган сумын 10 жилийн дунд сургуулийн багш
40. Бандийн Сарантуяа - Дорноговь аймгийн Улаанбадрах сумын багийн бага эмч
41. Сандагийн Солонго - Нийслэлийн Төрийн сангийн ерөнхий нягтлан бодогч
42. Жодов-Ишийн Сүхбаатар - Нийслэлийн Налайх дүүргийн нийтийн аж ахуйн "Чандмань-Налайх" компанийн хүний нөөцийн менежер
43. Дамдин-Очирын Сэлэнгэ - Нийслэлийн Хан-Уул дүүргийн ЗДТГ-ын зохион байгуулагч
44. Равдангийн Түмэн-Өлзий - Говь-Алтай аймаг дахь Говийн их дархан цаазат газрын захиргааны жолооч
45. Авирмэдийн Тунгалаг - Нийслэлийн Хан-Уул дүүргийн ЗДТГ-ын зохион байгуулагч
46. Жанчивын Уранчимэг - Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын референт
47. Доржийн Цогзолмаа - Хэнтий аймгийн Дадал сумын хүний их эмчийн салбарын бага эмч
48. Далайн Цэнд - Нийслэлийн Баянгол дүүргийн ЗДТГ-ын зохион байгуулагч
49. Балжирын Цэрэндорж - ШУТИС-ийн харьяа "Эрдэнэт" үйлдвэрийн дэргэдэх Технологийн сургуулийн техник лаборант
50. Самдангийн Цэсүрэн - Нийслэлийн Хан-Уул дүүргийн Статистикийн албаны мэргэжилтэн
51. Ринчинбазарын Чинбат - ШУТИС-ийн харьяа "Эрдэнэт" үйлдвэрийн дэргэдэх Технологийн сургуулийн багш
52. Бэгзжавын Чулуунбаатар - Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын "Их-Овоо трейд" компанийн жолооч
53. Шаравын Чулуунхүү - Нийслэлийн Хан-Уул дүүргийн ЗДТГ-ын зохион байгуулагч
54. Шаравын Чулуунцэцэг - Нийслэлийн Хан-Уул дүүргийн 3 дугаар хорооны Засаг дарга
55. Төрбатын Шүрхүү - Нийслэлийн Баянзүрх дүүргийн ЗДТГ-ын нийгмийн ажилтан
56. Гомбожавын Энх-Амгалан - Сүхбаатар аймгийн Халзан сумын Засаг даргын орлогч

57. Бадамын Эрдэнэбаяр - Дархан-Уул аймгийн "Дархан нэхий" ХК-ийн ажилчин

58. Нацагийн Эрдэнэцогт - Нийслэлийн Налайх дүүргийн 1 дүгээр хорооны өндөр настан, ахмад жолооч

### ЦЭРГИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Цэвээний Баянжаргал - Нийслэлийн Хан-Уул дүүргийн Онцгой байдлын хэлтсийн гал унтраах 14 дүгээр ангийн дарга, шадар ахмад

2. Цэвээндоржийн Ганболд - Нийслэлийн Налайх дүүргийн Цагдаагийн хэлтсийн хорооны цагдаа, цагдаагийн ахлах ахлагч

3. Даржаагийн Ганхуяг - Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Онцгой байдлын хэлтсийн гамшгаас хамгаалах асуудал хариуцсан мэргэжилтэн, шадар ахмад

4. Миезгийн Хоролсүрэн - Дорнод аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн газрын цагдаа

5. Дөнгөтийн Чулуунпүрэв - Нийслэлийн Налайх дүүргийн Цагдаагийн хэлтсийн эрүүгийн төлөөлөгч, цагдаагийн хошууч

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Н.ЭНХБАЯР**

### МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 10 дугаар сарын 27-ны өдөр

Дугаар 75

Улаанбаатар хот

**В.С.Литвиненко, Ю.В.Лыков нарыг одон, медалиар шагнах тухай**

Монгол Улс, Оросын Холбооны Улсын боловсролын салбарын хамтын ажиллагааг бэхжүүлэх, манай улсын уул уурхайн салбарын мэргэжлийн боловсон хүчин бэлтгэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж ОХУ-ын Санкт-Петербург хотын Уул уурхайн дээд сургуулийн ректор Владимир Стефанович Литвиненког "Алтан

гадас" одонгоор, мөн сургуулийн гадаадын оюутны хэрэг эрхэлсэн декан Юрий Васильевич Лыковыг "Найрамдал" медалиар тус тус шагнасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Н.ЭНХБАЯР**

### МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 10 дугаар сарын 28-ны өдөр

Дугаар 76

Улаанбаатар хот

**Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг баримтлан ЗАРЛИГ БОЛГОХ нь:

элчин сайд Готовдоржийн Луузанг эгүүлэн татсугай.

2. Монгол Улсаас Бүгд Найрамдах Португал Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайдаар Раднаабазарын Алтангэрэлийг томилсугай.

1. Монгол Улсаас Бүгд Найрамдах Португал Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Н.ЭНХБАЯР**

### МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2005 оны 10 дугаар сарын 28-ны өдөр

Дугаар 77

Улаанбаатар хот

**Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг баримтлан ЗАРЛИГ БОЛГОХ нь:

элчин сайд Цэндийн Батбуянг эгүүлэн татсугай.

2. Монгол Улсаас Испанийн Вант Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайдаар Раднаабазарын Алтангэрэлийг томилсугай.

1. Монгол Улсаас Испанийн Вант Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

Засгийн газрын 2005 оны 202 дугаар  
тогтоолын 1 дүгээр хавсралт

### МОНГОЛ УЛСЫН БАРУУН БҮСИЙН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР\*

(2006-2015 он)

2.2. Хэрэглээний бүтцийг сайжруулах талаар

**Үндэслэл:** Баруун бүсийн хүн амын хэрэглээний бүтцэд сүүлийн жилүүдэд эерэг өөрчлөлт гарч байгаа боловч хэрэглээний нэр төрөл харьцангуй цөөн, хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага зохих түвшинд хангагдахгүй байна.

Хөдөөгийн болон суурин газрын чинээлэг, ядуу иргэдийн хооронд хэрэглээний нэр төрөл, чанарын ялгаа өндөр зөрүүтэй байна. Төв, суурин газрын хүн амын хүнсний хэрэглээнд гурил, будаа, саахар, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, өндөг зонхилж байхад хөдөөгийнхний хэрэглээ мах, сүү, гурил, будаанаас төдийлөн хэтэрч чадахгүй байна. Ялангуяа ядуу, нэн ядуу өрхийн хэрэглээний түвшин үлэмж дор байна.

Үйлдвэрлэл, үйлчилгээнд ч техник, технологийн хоцрогдлоос үүдсэн үрэлгэн, зохисгүй хэрэглээ зонхилсоор байна. Цэвэр, бохир усны шугам, цэвэрлэх байгууламжтай сумын төв бараг байхгүй байна.

Иймд хүн амын чинээлэг болон ядуу хэсгийн хэрэглээний түвшингийн зөрүүг багасгаж нэр төрөл, чанарт нь ахиц гаргах, үйлдвэрлэлийн хэрэглээг өөрчлөн хүрээлэн буй орчинд сөрөг нөлөө үзүүлдэг зохисгүй хэрэглээг халж, ухаалаг, чанартай хэрэглээг бий болгон төлөвшүүлэх шаардлагатай байна.

#### Нэгдүгээр үе шат (2006-2010 он):

**Тэргүүлэх зорилт 1.** Бүс нутгийн хэмжээнд хүнсний барааны хангамжийг сайжруулж, хүнсний болон ахуйн шинэ зохистой хэрэглээг төлөвшүүлнэ.

#### Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

§ өргөн хэрэглээний барааны бөөний худалдааны сүлжээ, түүхий эдийн зах, үйлчилгээний цогцолборуудыг хөгжүүлэх;

§ "Ногоон хувьсгал", "Цагаан хувьсгал", "Хүнсний хангамж, аюулгүй байдал ба хоол тэжээл" үндэсний хөтөлбөрүүдийг бүсийн хэмжээнд эрчимтэй хэрэгжүүлэх;

§ бүсийн хүн амын хоол хүнсний физиологийн нормыг нас, хүйсний онцлогт нийцүүлэн шинэчлэн тогтоож мөрдөх;

§ баяжуулсан болон зориулалтын хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээг нэмэгдүүлэх;

§ түүхий эдийн нөөцдөө тулгуурлан экологийн цэвэр бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хэрэглээг нэмэгдүүлэх;

§ хүн амын сүү, сүүн бүтээгдэхүүний 60 хүртэл хувийг, цөцгийн тосны 40 хувийг бүсийн дотоодын үйлдвэрлэлээр хангах;

§ сумдын төв, өрхийн аж ахуйд тахиа, шувуу, гахайн аж ахуйг хөгжүүлэн өндөг, тахиа, гахайн махны хангамжийг сайжруулах;

§ жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих бодлогын хүрээнд төмс, хүнсний ногооны тариалан эрхлэгчдийг урт хугацааны бага хүүтэй зээл (лизинг)-ээр урамшуулах арга хэмжээ авах;

§ хүн амын эмзэг хэсэгт хамрагдаж байгаа хүүхэд, жирэмсэн ба хөхүүл эхчүүдийг иоджуулсан давс, бичил бодисоор баяжуулсан гурилаар хангах зохион байгуулалтын арга хэмжээ авах.

**Гарах үр дүн:** 2003 оны түвшинтэй харьцуулахад бүсийн хүн амын төмс, хүнсний ногооны хангамж 10-20 хувь, жимс жимсгэний хангамж 10 хувь, цөцгийн тосны хангамж 50-60 хувь, загас, загасан бүтээгдэхүүний хангамж 5 хувь өссөн байна.

**Тэргүүлэх зорилт 2.** Хүн амд ухаалаг, зохистой хэрэглээний мэдлэг олгоно.

#### Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

§ зохистой хэрэглээг бий болгох, хүнсний аюулгүй байдлыг хангах чиглэлээр төрөлжсөн болон сэдэвчилсэн сургалтууд тогтмол зохион байгуулах;

§ хүн амд иоджуулсан давс, баяжуулсан хүнс хэрэглэж сургах сургалтууд тогтмол зохион байгуулах;

§ хүний эрүүл мэндэд хортой архи, тамхи болон стандартын бус бүтээгдэхүүний хэрэглээг

\*Үргэлжлэл, түүрүү нь "Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 2005 оны №41 дүгээрт

бууруулах зорилгоор энэ талын сургалт, сурталчилгааг өргөтгөх;

- § хүн амд зохистой хэрэглээний талаар сургалт, сурталчилгаа явуулахдаа боловсрол, соёл, харилцаа холбооны байгууллагуудыг өргөн ашиглах.

**Гарах үр дүн:** Хүн амын хэрэглээний мэдлэг төлөвшиж, амьдралын байнгын хэвшил болох үндэс суурь тавигдана.

**Тэргүүлэх зорилт 3.** Байгаль орчинд хоргүй, дэвшилтэт технологийг тууштай нэвтрүүлэх замаар үйлдвэрлэлийн зохистой хэрэглээ бий болгох үндэс суурийг тавина.

### Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- § дэвшилтэт техник, технологи бүхий жижиг, дунд үйлдвэрүүдийг бүсийн тулгуур төв, аймаг, сумын төвд байгуулах замаар үйлдвэрлэлийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх;
- § түлшний модны хэрэглээг багасган байгалийн хий болон бусад төрлийн түлш ашиглах, барилга, модон эдлэлийн үйлдвэрлэлд өөр нэр төрлийн материал орлуулан хэрэглэхийг дэмжин урамшуулах;
- § ундны усны баталгаат эх үүсвэрийн хүртээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээ авах;
- § үйлдвэрлэлийн хог хаягдлыг хоргүйжүүлэх, халдваргүйжүүлэх, хортой хаягдлыг устгах зориулалт бүхий үйлдвэрлэлийг шинээр бий болгон хөгжүүлэх;
- § хог хаягдал, бохир ус зайлуулах, устгах, ялган боловсруулах, цэвэршүүлэх төсөл шалгаруулан аж ахуйн нэгж, байгууллагаар гүйцэтгүүлэх;
- § үйлдвэрлэлийн болон хүн амын хэрэглээний явцад гарсан хог хаягдлыг бууруулах, дахин боловсруулж ашиглах;
- § орчныг бохирдуулагч нь илүү төлбөр төлөх зарчмыг тууштай хэрэгжүүлэх.

**Гарах үр дүн:** Орчин үеийн технологид суурилсан жижиг, дунд үйлдвэрлэл хөгжин үйлдвэрлэлийн хэрэглээг шинэчлэгдэх үндэс суурь тавигдсан байна.

**Тэргүүлэх зорилт 4.** Төв, суурин газрын гэр хорооллын хүн амын усан хангамжийн түвшинг дээшлүүлж, усны зохистой хэрэглээг төлөвшүүлнэ.

### Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- § төв, суурин газрын цэвэр, бохир усны системийн техник технологийг шинэчлэх зорилгоор бүсийн аймгийн төвүүдэд цэвэр ус дамжуулах шугам

тавих, гэр хорооллын усан хангамжийг сайжруулах;

- § төвлөрсөн усан хангамжийн сүлжээнд холбогдоогүй газруудыг уг сүлжээнд хамруулах;
- § эрдэсжилт өндөр болон хатуулаг ихтэй усны чанарт хяналт-шинжилгээ хийх, ус цэвэршүүлэх тоног төхөөрмжийн хангамжийг сайжруулах;
- § стандартын шаардлага хангадаггүй ахуйн хэрэглээний усны эх үүсвэртэй төв, суурин газар, цэргийн ангид ус цэвэршүүлэх техник, технологи нэвтрүүлэх;
- § хөдөө орон нутагт гүний худгийг сэргээн засварлаж, дундын эзэмшлийн гэрээ байгуулах замаар эзэнтэй болгож, хүн амын цэвэр усны хүртээмжийг сайжруулах;
- § найрлагын хувьд стандартын шаардлага хангасан цэвэр ус, рашаан савлах жижиг, дунд үйлдвэр байгуулахыг бүх талаар дэмжих;
- § гэр хорооллын усан хангамжийг сайжруулах, усны зохистой хэрэглээг бий болгоход хувийн хэвшлийн оролцоог идэвхжүүлэхэд чиглэсэн хөшүүргүүдийг хэрэглэх;
- § усыг зохистой хэрэглэх, хадгалж хамгаалах талаар мэдээлэл, сургалт сурталчилгааг тогтмол зохион байгуулах.

**Гарах үр дүн:** Хүн амын усан хангамжийн болон ундны усны эрүүл ахуйн стандартын шаардлага хангах түвшин мэдэгдэхүйц дээшилнэ.

### Хоёрдугаар үе шат (2011-2015 он):

**Тэргүүлэх зорилт 1.** Хүн амын хүнсний хангамж, хэрэглээний бүтцийг өөрчлөн сайжруулна.

### Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- § бизнес эрхлэх таатай орчин бүрдүүлэх замаар аж ахуйн нэгж, өрхийн үйлдвэрлэлийг дэмжиж, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, цөцгийн тосны үйлдвэрлэлийг өсгөн, дотоодын зах зээлд загас, загасан бүтээгдэхүүний нийлүүлэлтийг тогтмол нэмэгдүүлэх;
- § хүн амын сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэглээг 60-70 хүртэл хувиар өсгөх арга хэмжээ авах;
- § аж ахуйн нэгж, өрхийн үйлдвэрлэлийг дэмжин хүнсний шинэ бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах;
- § хүнсний аюулгүй байдлыг хангах, хүнсний барааны чанар, стандарт, эрүүл ахуйн үзүүлэлтийг өндөр нарийвчлалтай баталгаажуулдаг тогтолцоог бий болгох;





§ бага насны хүүхэд, жирэмсэн, хөхүүл хүүхэдтэй эхчүүд, ахмад настны болон тусгай хоол хэрэглэдэг бүлгийн хүмүүсийн хоол тэжээлийг үйлдвэрлэх, хадгалах, түгээх үйлчилгээний сүлжээг бий болгох;

§ бичил бүсийн болон сумын төвүүдэд зохистой хэрэглээг төлөвшүүлэх сургалтуудыг чанаржуулан тогтмол зохион байгуулах.

**Гарах үр дүн:** 2003 оны түвшинтэй харьцуулахад төмс, хүнсний ногооны хангамж 30 хувь, жимс жимсгэний хангамж 15 хувь, загас, загасан бүтээгдэхүүний хангамж 10 хувь өссөн байна.

**Тэргүүлэх зорилт 2.** Байгаль орчинд халгүй, дэвшилтэт технологийг тууштай нэвтрүүлэх замаар үйлдвэрлэлд зохистой хэрэглээг төлөвшүүлнэ.

**Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:**

§ түлшний мод хэрэглэхийг багасган байгалийн хий болон бусад төрлийн түлш хэрэглэх, барилга, модон эдлэлийн үйлдвэрлэлд өөр төрлийн материал орлуулан ашиглахад чиглэсэн дэвшилтэт технологийг дэмжин урамшуулах;

§ баяжуулсан хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл, хангамжийг сайжруулах чиглэл бүхий үйлдвэрүүдийг түлхүү дэмжих;

§ байгаль орчинд халгүй, дэвшилтэт техник, технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх зорилгоор энэ талын хяналтыг хүчтэй болгох арга хэмжээ авах;

§ бүсийн аймгуудад үйлдвэрлэлийн болон хэрэглээний явцад гарсан хог хаягдлыг төрөлжүүлэн дахин боловсруулах үйлдвэрүүд байгуулах.

**Гарах үр дүн:** Үйлдвэрлэлийн хэрэглээний бүтэц, чанарт өөрчлөлт гарч, хүн амын эрүүл мэндэд хоргүй бүтээгдэхүүн үйлдвэрлэх нөхцөл сайжирна.

**Тэргүүлэх зорилт 3.** Төв, суурин газрын хүн амыг эрүүл ахуйн шаардлага хангасан цэвэр усаар хангах ажлыг сайжруулж, усан хангамжийн түвшинг дээшлүүлнэ.

**Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:**

§ төв, суурин газрын хүн амын ундны ба ахуйн хэрэглээний усны эх үүсвэрт ариун цэвэр, эрүүл ахуйн хамгаалалтын бүс тогтоож, тэжиуулах ажлыг сайжруулах;

§ бүсийн аймгуудын ундны усны зарим шинэ эх үүсвэрийг судлан тогтоож, сумын ундны усны

худгуудад цэнгэгжүүлэх тоног төхөөрөмж суурилуулан, усны чанар, хангамжийг сайжруулах;

§ эрүүл ахуйн шаардлага хангасан цэвэр ус савлан, хот, хөдөөгийн иргэдийн эрэлт хэрэгцээг хангах ажлыг өргөтгөх;

§ усыг ариг гамтай хэрэглэх талаархи мэдээлэл, сурталчилгааг тогтмолжуулах.

**Гарах үр дүн:** Хүн амыг эрүүл ахуйн стандартын шаардлага хангасан цэвэр усаар хангах боломж, нөхцөл сайжирна.

2.3. Ажилгүйдэл, ядуурлыг бууруулах талаар

**Үндэслэл:** 2004 оны байдлаар ажилгүйдлийн түвшний улсын дундаж 3.6 хувь байхад Баруун бүсэд 5.3 хувьтай байна.

Энэ нь Баруун бүсийн эдийн засгийн хөгжлийн түвшин бусад бүсээс харьцангуй доогуур байгаатай шууд холбоотой. Шилжилтийн эхний жилүүдэд улсын хэмжээгээр үндэсний орлого огцом буурч, ажилгүйдэл ихсэн, инфляци огцом өсөж, нийгмийн салбарын санхүүжилт буурснаар ядуурал газар авсан билээ. Өмнөх тогтолцооны үед бий болсон ажлын байрууд үгүй болж тэндээс амьжиргаагаар залгуулж байсан хүмүүсийн ихэнх нь ажилгүйдлийн эгнээнд шилжиж орсон ба нэлээд хэсэг нь шилжсэн байна. Нөгөө талаар иргэд бизнес эрхлэж бие даан амьдрах мэдлэг, дадлага, туршлага дутмаг, бэлэнчлэх сэтгэлгээнээс салж чадахгүй байгаагаас ажилгүйдлийг дагасан ядуурал өсч байна. Баруун бүсэд сүүлийн жилүүдэд жил дараалан тохиолдсон ган, зудад нэрвэгдсэн олон айл өрх малгүй болж, сум, аймгийн төв болон хот, суурин газрыг барааджээ.

2002-2003 оны өрхийн орлого, зарлага, амьжиргааны түвшний судалгааны дүнгээр Баруун бүсэд ядуурлын хамралтын хүрээ 51.1 хувь, ядуурлын гүнзгийрэлт 14.6 хувь, ядуурлын мэдрэмж 5.7 хувьтай байна. Судалгаагаар малчин өрхийн нэг хүнд ногдох малын тоо 20 бодоос дээш байж ядууралд хамрагдахгүй байх боломжтой. Гэтэл Баруун бүсийн олонхи малчин өрхийн нэг хүнд ногдох малын тоо 20 бодоос доогуур байна. Иймд ажилгүйдлийн түвшинг энэ бүс нутагт эрс бууруулж, хүн амыг ядуурлаас гаргах талаар дорвитой алхмууд хийх шаардлагатай байна.

**Нэгдүгээр үе шат (2006-2010 он):**

**Тэргүүлэх зорилт 1.** Ажилгүйдлийн түвшинг бууруулж, амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой өрхийн нийгмийн хамгаалал, халамжийг сайжруулна.

## Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- § сум, бичил бүсийн төвийн түвшинд "Нийгмийн халамж, үйлчилгээний төв", орон нутгийн хөгжлийн төвүүдэд Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, тулгуур төв хотуудад нийгмийн хамгаалал, даатгал, хөдөлмөр эрхлэлтийн иж бүрэн үйлчилгээг нэг цэгээс үзүүлэх "Нийгмийн хамгааллын төв"-ийг ажиллуулах;
- § бүсийн төвүүдэд хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн мэдээлэл сургалтын төв байгуулж, мэдээллийн нэгдсэн сүлжээгээр үйлчилдэг болох;
- § сумын нийгмийн үйлчилгээний төв, аймгуудын нийгмийн халамжийн албадын ажилтнуудыг бүсчилсэн байдлаар давтан сургах хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх;
- § Улаангом хот дахь "Улаангом" коллежийг түшиглэн хөдөлмөр эрхлэлтийн мэргэжил, арга зүйн зөвлөлтөө өгөх чиг үүрэг бүхий "Бүсийн арга зүйн төв" байгуулах;
- § сум дундын нийгмийн халамжийн мэдээллийн нэгдсэн сүлжээ байгуулан, өргөжүүлэх;
- § нийгмийн даатгалд хамрагдах хүрээг нэмэгдүүлж, тэтгэврийн суурь даатгалын тогтолцоонд бүсийн хүн амыг бүрэн хамруулах;
- § сайн дурын үндсэн дээр хөдөлмөр, хөрөнгөө нэгтгэн хоршоо, фермерийн аж ахуй, нөхөрлөл байгуулахыг дэмжих, жижиг, дунд үйлдвэрлэлийг өргөтгөх замаар ажлын байрыг нэмэгдүүлэх;
- § ядуурлаас өөрөө гарах гэсэн иргэдийн санал санаачилгыг төр, олон нийт, аж ахуйн байгууллагууд дэмжиж, энэ талын сургалт, сурталчилгааг өргөтгөх;
- § ажилгүй иргэдэд шинэ мэргэжил олгох, мэргэшлийн үр чадварыг дээшлүүлэх чиглэлээр үйлдвэрлэл дээр сургалт зохион байгуулсан ажил олгогчдыг урамшуулан дэмжих;
- § хөдөлмөр эрхлэлтийн албаны үйл ажиллагааг өргөтгөх, дотоод, гадаадын хөдөлмөр-зуучлалын үйлчилгээ үзүүлж эхлэх;
- § малчдыг мал аж ахуйн бус орлогын эх үүсвэртэй болох нөхцөлийг бүрдүүлэх арга хэмжээ авах;
- § ядуурлыг бууруулах хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд иргэд болон иргэний нийгмийн байгууллагуудыг өргөнөөр оролцуулах.

**Гарах үр дүн:** Амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой өрхийн тоо 2002 оны түвшингээс 30 хувиар, ажилгүйдлийн түвшин 3.0 хувь болж тус тус буурсан байна.

**Тэргүүлэх зорилт 2.** Нийгмийн эмзэг бүлэгт чиглэсэн халамж, үйлчилгээг сайжруулна.

## Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- § бичил бүс, аймгийн төвүүдэд ажилгүйчүүд, нийгмийн ядуу хэсэгт зориулсан мэргэжил олгох чиг үүрэг бүхий хөдөлмөр эрхлэлтийн болон сургалтын төвүүдийг байгуулж, ажиллуулах;
- § "Тогтвортой амьжиргааг дэмжих" төслийн хүрээнд ядуу, эмзэг хэсэгт туслах зорилгоор санхүүгийн үйлчилгээг сайжруулах;
- § бүтэн өнчин, тэнэмэл, нэн ядуу өрхийн хүүхдүүдийг байрлуулж хооллон, сургалт явуулах халамжийн төвүүдийн үйлчилгээг нэмэгдүүлэн, амьдралын арга ухааныг зааж сургах ажлыг өргөжүүлэх;
- § ядуу иргэд, орон гэргүй хүмүүсийг гэр, хашаа, орон сууц худалдан авах, барих, орон байраа өргөтгөх, засварлах боломж олгох зорилгоор орон сууцны эзэлийн үйлчилгээг сайжруулах;
- § хоол тэжээлийн дутагдалд орж буй шалтгаан, нийгмийн үр дагаврыг судлан ядуу иргэдийн хоол хүнсний хангамжийг нэмэгдүүлэх арга хэмжээ авах;
- § тахир дутуу иргэдэд үзүүлэх үйлчилгээний хүрээ, хүртээмжийг нэмэгдүүлэх;
- § ахмад настанд үзүүлж байгаа тусламж, хөнгөлөлтийг боловсронгуй болгох.

**Гарах үр дүн:** Эмзэг бүлгийн хүмүүст үзүүлэх нийгмийн хамгааллын тогтолцоо боловсронгуй болж, иргэдэд үзүүлэх нийгмийн халамжийн үйлчилгээний хүртээмж сайжирна.

## Хоёрдугаар үе шат (2011-2015 он):

**Тэргүүлэх зорилт 1.** Амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой өрх, иргэдийг амьжиргааны тогтвортой эх үүсвэртэй болгож, нийгмийн хамгааллын хүртээмж, үйлчилгээг шинэ шатанд гаргана.

## Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- § жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ, хоршоо, фермерийн аж ахуй байгуулах, аялал жуулчлал хөгжүүлэх, байгаль хамгаалах, нөхөн сэргээх чиглэлээр хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхийг бүх талаар дэмжих;

§ бичил аж ахуйн нэгжийн чадавхийг нэмэгдүүлэх зорилгоор бизнес-инкубаторын төвийг бүсийн аймгуудад байгуулах;

§ залуучуудад ажлын байр шинээр бий болгож байгаа аж ахуйн нэгж, иргэдэд татварын бодлогоор хөнгөлөлт үзүүлэх;

§ "Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих" дэд хөтөлбөрийг хоршоо, фермерийг дэмжих бодлоготой нягт уялдуулан хэрэгжүүлэх.

**Гарах үр дүн:** Ажилгүйдлийн түвшин 2.0 хувь, амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой иргэдийн хувь хэмжээ хоёр дахин буурна.

**Тэргүүлэх зорилт 2.** Нэн ядуу иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд чиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээг сайжруулна.

### Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

§ бүсийн асрамж, халамжийн төвүүдийн үйл ажиллагааг чанаржуулж, бүтэн өнчин, орон гэргүй, тэнэмэл болон нэн ядуу өрхийн хүүхдийг байрлуулж хооллон, сургалт явуулах халамж үйлчилгээний төвүүдийг шаардлагатай газарт шинээр байгуулж, амьдралын арга ухааныг зааж сургах;

§ хөдөлмөр эрхлээгүй хүмүүс, ялангуяа нийгмийн эмээг бүлгийн иргэдийг дэд бүтэц, хот, нийтийн аж ахуйн болон нийгмийн эзэмшлийн зам талбай, ногоон байгууламжийн төхижилт, үйлчилгээний зарим ажлыг гэрээгээр гүйцэтгүүлэх тогтолцоонд шилжих;

§ "Нийгмийн халамжийн сан"-гийн үйл ажиллагааны үр өгөөжийг нэмэгдүүлэх;

§ тахир дутуу иргэдэд үзүүлэх дэмжлэг, үйлчилгээний хүрээ, хүртээмжийг тэдний амьдралын чанар, онцлогийг харгалзан нэмэгдүүлэх;

§ ахмад настанд үзүүлж байгаа тусламж, хөнгөлөлтийг сайжруулж, өрхийн тэтгэмжийн төрлийг шинээр бий болгох.

**Гарах үр дүн:** Ажлын байр нэмэгдэн, нийгмийн халамж, асрамж, үйлчилгээний чанар, хүртээмж дээшлэн, нэн ядуу өрх, иргэдийн тоо 2 дахин цөөрч, ядуурал мөн хэмжээгээр буурна.

2.4. Хүн амын боловсрол, соёлын түвшинг дээшлүүлэх талаар

**Үндэслэл:** Баруун бүсэд 8-15 насны 100 хүүхэд дутмын 80 орчим нь ерөнхий боловсролын

сургуульд суралцаж байгаа нь сургууль завсардалт их байгааг харуулж байна. Сургууль завсардалтаар хамгийн их байгаа Хангайн бүсийн дараа энэ бүс орж байна. Завхан, Увс, Баян-Өлгий аймгуудад сургууль завсардалт харьцангуй өндөр үзүүлэлттэй байна. Сургууль завсардалтын шалтгаан нь хүн амын ядуурлаас гадна малчдын мал аж ахуйдаа түлхүү ач холбогдол өгөх сэтгэлгээ давамгайлах, сургуулийн дотуур байрны хүрэлцээ муу байгаа зэрэг хэд хэдэн хүчин зүйлстэй холбоотой байна.

Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвүүд болон дээд сургуулиудын мэргэжлийн чиглэлийг бүсийн хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдтэй уялдуулан өөрчлөх, бүс нутаг шаардлагатай мэргэжилтнүүдийг бэлтгэх зорилт тулгарч байна. Бүс нутгийн хөгжлийн асуудлуудаар дорвитой судалгаа, дүгнэлт гаргах чадвар бүхий эрдэм шинжилгээний байгууллага ч үгүйлэгдэж байна.

Соёл, урлагийн байгууллагуудын урын сангийн баяжилт, урлагийн ажилтнуудын ажил, амьдралын нөхцөл, мэргэжлийн ур чадвар, иргэдэд үзүүлэх соёл, урлагийн үйлчилгээний чанар шаардлагын түвшинд хүрэхгүй байна. Иймд боловсрол, соёлын байгууллагуудын зэрэглэл, үйлчилгээний төрөл, хүртээмжийг дээшлүүлэх, бүсийн боловсрол, соёл, шинжлэх ухааны нэгдмэл, үр ашигтай тогтолцоо бүрдүүлэх шаардлагатай байна.

Нэгдүгээр үе шат (2006-2010 он):

**Тэргүүлэх зорилт 1.** Боловсролын салбарын шинэчлэлийг гүнзгийрүүлж, бүх шатны сургуулиудын сургалтын чанарыг сайжруулна.

### Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

§ ерөнхий боловсролын сургуулиудын байршил, хэв шинжийг орон нутгийн засаг захиргааны нэгжийн өөрчлөлттэй уялдуулан оновчтой тогтоох;

§ сургуулийн өмнөх боловсрол олгох сургалтын оновчтой арга, хэлбэрүүдийг нэвтрүүлэх замаар хөдөөгийн малчдын хүүхдийн хамран сургалтыг нэмэгдүүлэх;

§ сургууль завсардах явдлыг эрс багасган, суурь боловсролын хамран сургалт /бохир жин/-ыг нэмэгдүүлэх;

§ аймга дундын мэргэжлийн болон гүнзгийрүүлсэн сургалттай дунд, ахлах сургууль байгуулах ажлыг дэмжих;

§ ерөнхий боловсролын сургуулийг 11 жилийн сургалтын тогтолцоонд бүрэн шилжүүлж, 12 жилийн тогтолцоонд шилжих бэлтгэлийг ханган, шилжиж эхлэх;

- § мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн зарим ажил, үйлчилгээг гэрээ, түрээсийн хэлбэрт шилжүүлэх;
- § англи хэлний хоёр албан хэл болгоход чиглүүлэн сургалтыг чанаржуулах, мөн орос, хятад хэлний гүнзгийрүүлсэн сургалт явуулах;
- § сургууль завсардсан хүүхэд, залуучуудад боловсрол нөхөн эзэмшүүлэх, ажил мэргэжлийн чадвар, дадалтай болгох ажлыг зохион байгуулах;
- § бүрэн ба бүрэн бус дунд боловсрол эзэмшигчдэд мэргэжлийн боловсролыг давхар эзэмшүүлэх арга хэмжээ авах;
- § төрийн бус өмчийн сургуулийг аймаг, сумдын төвд байгуулан ажиллуулахад бүх талын дэмжлэг үзүүлэх;
- § малчдын хүүхдийг сургуульд бэлтгэх оновчтой арга хэлбэрийг сонгох, тухайлбал явуулын багштай нүүдлийн болон гэр цэцэрлэг ажиллуулах;
- § багийн бага сургуулиудыг тохижуулж, оройн ба эгнээ сургалт явуулан, ялангуяа эмзэг бүлгийн хүүхдийн сургууль хамрагдалтыг нэмэгдүүлэх;
- § боловсрол, соёлын байгууллагын удирдлагын чадавхийг дээшлүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах нөхцөлийг бүрдүүлэх;
- § хөдөөгийн сургуулиудыг мэргэжлийн багшаар хангах, тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэж, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх;
- § төрийн өмчийн дээд боловсролын байгууллагуудыг төрөлжүүлэн нэгтгэхийн сацуу дэргэд нь багшлах боловсон хүчний мэргэжил дээшлүүлэх сургалт-мэдээллийн төвүүдийг байгуулах;
- § бүсэд шаардагдах бакалаврын зэрэгтэй мэргэжилтэн бэлтгэх их, дээд сургуулийн оновчтой тогтолцоо бүрдүүлэх, эрдэмтэн багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалт-мэдээллийн төвүүд байгуулах;
- § шаардлагатай мэргэжилтнүүдийг бүсийн хэмжээнд бэлтгэх нөхцөлийг бүрдүүлэх, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвүүдийн үйл ажиллагааг өргөтгөх;
- § залуучуудыг өндөр хөгжилтэй орнуудад сургах арга хэмжээ авах;
- § гадаад орнуудын их, дээд сургуулиудтай хамтын ажиллагаагаа өргөтгөх;
- § Ховд хот дахь Их сургуулийг түшиглэн Баруун бүсийн багш нарын мэргэжил дээшлүүлэх болон эрдэм шинжилгээний салбар байгууллагыг нээн ажиллуулах;
- § Улиастай хот дахь Санхүү эдийн засгийн салбар сургуулийг өргөтгөж, бүсийн хэмжээнд эдийн засаг, бизнесийн удирдлага, хөдөө аж ахуйн мэргэжилтэн бэлтгэх чиглэлээр бэхжүүлэх;
- § их, дээд сургуультай хоршсон шинжилгээ судалгааны төрөлжсөн байгууллага, салбар, мэдээллийн технологийн төвүүд байгуулж ажиллуулахыг урамшуулан дэмжих;
- § өндөр мэргэжилтэй багш нар, соёлын төвийн ажилтнуудыг орон нутагт ажиллуулах эдийн засгийн урамшууллын шинэ хөшүүрэг бий болгох.

**Гарах үр дүн:** Боловсролын тогтолцоо болон сургалтын байгууллагын хэв шинж, үйл ажиллагаа олон улсын жишигт ойртоно.

**Тэргүүлэх зорилт 2.** Албан бус боловсролын үйлчилгээний хүртээмж, чанар, үр ашгийг дээшлүүлнэ.

**Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:**

- § албан бус боловсрол олгох бүсийн нэгдсэн сүлжээ бий болгох хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх;
- § албан бус болон зайны сургалтыг хүн амд бичиг үсэг сургах, боловсролын түвшингээ дээшлүүлэх, бизнес, зах зээлийн мэдлэг, зохистой хэрэглээний чадвар олгоход чиглүүлэх;
- § албан бус боловсролын тогтолцоонд ажиллах орон тооны ба орон тооны бус багшийг 2-3 чиглэлээр мэргэшүүлэх;
- § хүн амын бие дааж боловсролоо дээшлүүлэх санаачилгыг идэвхтэй дэмжин, бие дааж суралцах зөвлөлгөө өгөх газруудыг аймгуудад байгуулан, үйл ажиллагааг нь жигдрүүлэх.

**Гарах үр дүн:** Албан бус боловсрол ба зайны сургалтын тогтолцооны үндэс суурь тавигдаж, менежмент нь сайжирна.

**Тэргүүлэх зорилт 3.** Боловсролын байгууллагуудын материаллаг баазыг бэхжүүлнэ.

**Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:**

- § бүсийн цэцэрлэгүүдийн тоглоом наадгай, ерөнхий боловсролын сургуулиудын сургалтын

техник хэрэгсэл, компьютерийн хангамжийг сайжруулж, номын сангийн фондыг нэмэгдүүлэх;

§ хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн болон дотуур байрыг засварлах ажлыг дэс дараатай эхлүүлж, зарим сумдад ерөнхий боловсролын сургуулийн барилгыг өргөтгөх;

§ бүсийн хэмжээнд шаардлагатай мэргэжилтэй ажилчид бэлтгэх сургалт, үйдвэрлэлийн төвүүдийг байгуулж, үйл ажиллагааг нь бүсийн хэмжээнд үйлчлэх чиглэлээр зохион байгуулах;

§ боловсролын салбар дахь хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг бүх талаар дэмжин урамшуулах;

§ хөдөөгийн ерөнхий боловсролын сургуулийг интернетээр хангах, интернетийн сүлжээнд холбох арга хэмжээг хэрэгжүүлэх;

§ гадаад орны мэргэжлийн төрөлжсөн байгууллагууд, хандивлагчдаас боловсролын салбарын материаллаг баазыг бэхжүүлэх чиглэлээр төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхийг бүх талаар дэмжих.

**Гарах үр дүн:** Бүх шатны боловсролын сургуулиудын материаллаг бааз бэхжин, сургалтын чанарыг сайжруулахад үзүүлэх нөлөөлөл нь нэмэгдэнэ.

**Тэргүүлэх зорилт 4.** Урлаг, соёлын байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг сайжруулж, үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлнэ.

#### Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

§ суманд соёлын төв, бичил бүсийн төвд урлаг-соёл-спортын төв, орон нутгийн хөгжлийн төвд аймгийн соёлын ордон, театр, бүсийн тулгуур төвд мэргэжлийн урлаг-соёлын хосолсон үйлчилгээтэй байгууллагууд ажиллуулах замаар соёлын үйлчилгээний оновчтой тогтолцоог бүрдүүлэх;

§ угсаатны зүй, үндэстэн ястны соёлыг хадгалж хамгаалах төвийг тулгуур төвүүдийн аль нэгэнд байгуулах;

§ сумдын номын сан, соёлын төвүүдийн байрны хангамж, материаллаг баазыг бэхжүүлэн үйлчилгээг өргөжүүлж, хүн амд мэдээлэл хүргэх төв болгон ажиллуулах арга хэмжээ алах;

§ аймгуудын номын санг "Номын өргөө" болгон зохион байгуулж, түүний зохион байгуулалт,

үйлчилгээний төрөл хэлбэр, санхүүжилтийн механизмыг тогтоох;

§ бүсийн түүх, соёлын дурсгалт зүйлсийн бүртгэлийг мэдээллийн сүлжээнд оруулж, "Баруун Монголын язгуур урлаг" хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх, язгуур урлагийн сан байгуулах;

§ аймгийн соёл, урлагийн байгууллагуудыг менежментийн гэрээгээр хувьчилах, удирдлагын болон түрээсийн гэрээгээр ажиллуулах.

**Гарах үр дүн:** Хөдөөгийн хүн амд үзүүлэх соёл, урлагийн үйлчилгээний хүрээ өргөжиж, зах зээлийн нөхцөлд нийцсэн шинэ зохион байгуулалтад шилжсэн байна.

Хоёрдугаар үе шат (2011-2015 он):

**Тэргүүлэх зорилт 1.** Бүсийн боловсролын тогтолцоо, сургалтын хэв шинжийг олон улсын нийтлэг жишигт хүргэнэ.

#### Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

§ бүх нийтэд боловсрол олгох Мянганы хөгжлийн зорилтыг бүрэн хэрэгжүүлэх;

§ бүх шатны сургуулийн удирдлагын чадавхийг дээшлүүлэх;

§ ерөнхий боловсролын сургуулиудын сургалтыг 12 жилийн тогтолцоонд бүрэн шилжүүлэх;

§ мэргэжлийн сургалттай ахлах сургуулиуд байгуулах;

§ одоо байгаа ерөнхий боловсролын сургуулийг үйл ажиллагааны шалгуур, хүчин зүйлүүдээр /3-5 сургууль/ нэгтгэх замаар цогцолбор сургуулиуд байгуулах;

§ бичил бүсүүдийн төвийн сургуулиудыг хөрвөх чадвартай мэргэжлийн багшаар хангах;

§ сургалтын агуулга, технологийг шавь төвтэй сургалтад чиглүүлэх;

§ сургууль завсардалтыг үндсэнд нь зогсоож, бичиг үсэг үл мэдэх явдлыг бүрмөсөн арилгах;

§ боловсролын салбар дахь хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг бүх талаар дэмжин урамшуулах;

§ хүүхдийн унаган авъяас, давуу талыг эртнээс нээн илрүүлж, хөгжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх механизм бүрдүүлэх;

§ бүсийн тулгуур төв болон бусад аймгийн төвд мэргэжилтэн бэлтгэх ажлыг улам боловсронгуй болгон бүс нутгийн онцлог, хөгжлийн чиг хандлага, эрэлт хэрэгцээнд нийцүүлэх;

§ сургуулийн өмнөх боловсролын байгууллагын үйл ажиллагааны хүрээг өргөтгөж, үйлчилгээний чанарыг дээшлүүлэх;

§ бага, суурь, бүрэн дунд боловсролын хамран сургалт /бохир жин/-ыг нэмэгдүүлэх;

§ боловсролын байгууллагууд, аж ахуйн нэгж, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын үүсгэл санаачилгаар өрнүүлэх эрдэм шинжилгээ, сорилт туршилтын үйл ажиллагааг дэмжин урамшуулах;

§ шинэ мэдлэг, техник, технологийн мэдээллээр хангах шинжлэх ухаан-бизнесийн байгууллага хоорондын зуучлалын нэгж байгуулж ажиллуулах.

**Гарах үр дүн:** Сургууль завсардалт арилан, бүх шатны боловсролд хамрагдагсдын тоо нэмэгдэн хүн амын боловсролын түвшин дээшилнэ.

**Тэргүүлэх зорилт 2.** Албан бус боловсролын үйлчилгээний хүртээмж, чанар, үр ашгийг тасралтгүй дээшлүүлнэ.

### Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

§ сургууль завсардсан хүүхэд, залуучуудад боловсрол нөхөн эзэмшүүлэх, ажил мэргэжлийн чадвар, дадал олгох, хүн амын ерөнхий боловсролын түвшинг ахиулах сургалтуудыг зохион байгуулж, иргэдийг албан бус боловсролын үйлчилгээнд өргөн хамруулах;

§ иргэд албан бус тогтолцооны аль боломжит хэлбэрээр тасралтгүй боловсролоо дээшлүүлэх, амьдрах ухаанаа хөгжүүлэх шаарлагад нийцүүлэн бүсийн онцлогт тохирсон зайны сургалтын агуулга, арга зүй, үйлчилгээ, үйл ажиллагааны механизмыг бүрдүүлэх;

§ албан бус боловсрол олгоход шаардагдах техник хэрэгслийн хангамжийг эрс сайжруулах.

**Гарах үр дүн:** Иргэд тохиромжтой хэлбэрээр бололцоотой хугацаандаа боловсрол эзэмших нөхцөл бүрдэнэ.

**Тэргүүлэх зорилт 3.** Боловсролын байгууллагуудын материаллаг баазыг бэхжүүлж, боловсрол эзэмших хүрээг өргөтгөнө.

### Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

§ Ховд, Улиастайн мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийг Баруун бүсийн

мэргэжилтэй ажилчин бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, мэргэжил дээшлүүлэх төв болгон бэхжүүлэх;

§ сум бүрийн сургуулийн дотуур байрыг хэвийн ажиллуулах боломжийг бүрдүүлж малчдын хүүхдийн 70-аас доошгүй хувийг хамруулах хүчин чадалтай болгох;

§ сургуулийн байгууллагуудыг техник, тоног төхөөрөмж, үзүүлэн таниулах материал, сургалтын хэрэглэгдэхүүнээр бүрэн хангах;

§ ердийн галлагаатай хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулиудын халаалтын асуудлыг шийдвэрлэх;

§ хөдөөгийн сургууль, цэцэрлэгийг байнгын цахилгааны эх үүсвэртэй болгох;

§ албан бус боловсролын төвд сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, холбогдох хэрэглэгдэхүүнийг компьютерийн сүлжээгээр аймаг, сум руу түгээх нөхцөл бүрдүүлэх.

**Гарах үр дүн:** Бүх шатны сургуулиудад сурч боловсрох ая таатай нөхцөл бололцоо бий болно.

**Тэргүүлэх зорилт 4.** Соёл, урлагийн үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлнэ.

### Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

§ Сум дундын соёлын байгууллага байгуулж ажиллуулах;

§ урлагийн авьяастан, урчууд, уран бүтээлчдийг тодруулж дэмжих нэгдсэн төсөл хэрэгжүүлэх;

§ олон ястан, үндэстний түүх, урлаг, соёлын өвийг хадгалж хамгаалах, судлан шинжлэх, сурталчлах иж бүрэн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх;

§ номын сан, архивын үйлчилгээг хүн амын эрэлт хэрэгцээнд нийцүүлэн чанаржуулах.

**Гарах үр дүн:** Соёл, урлагийн байгууллагуудын биеэ даан ажиллах оновчтой тогтолцоо бүрдэн, төрийн түгээс үзүүлэх дэмжлэг, зохицуулалт сайжирна.

2.5. Хүн амын эрүүл мэндийг сайжруулах талаар

**Үндэслэл:** Баруун бүс нутагт эрүүл мэндийн салбарын боловсон хүчний хангамж, мэргэжлийн ур чадварын түвшин харилцан адилгүй, санхүүгийн чадавхи хязгаарлагдмал, материаллаг баазын хангамж, хүрэлцээ дутмаг, эрүүл мэндийн



анхан шатны үйлчилгээний чанар, хүртээмж шаардлагын түвшинд хүрэхгүй байна.

Баруун бүсэд бүсийн оношилгоо, эмчилгээний төв 1, аймаг бүрт нэгдсэн эмнэлгүүд, сум дундын эмнэлэг, сумын эмнэлэг, асрамж, сувиллын газар, өрхийн эмнэлгүүд ажиллаж байна. Ховдоод Бүсийн оношилгоо, эмчилгээний төв байгуулагдаад 3 дахь жилдээ ажиллаж байгаа боловч тархи, бөөрний оношилгооны зарим нарийн тоног төхөөрөмж дутагдалтай зэрэг шалтгааны улмаас нийслэлд ирж оношлуулах, эмчлүүлэх нь түгээмэл байна.

Эрүүл мэндийн үйлчилгээний анхан шатны тусламж, үйлчилгээ эмзэг бүлгийнхэнд бүрэн хүрч чадахгүй байна. Амьдралын түвшин доогуур өрхийн хүүхэд 2.5 дахин илүү өвчилж, 3 дахин илүү эмнэлэгт хэвтэж, мөн тэр хэмжээгээр эндэж байна.

Эндсэн эхийн 80 гаруй хувь нь малчин, 60 гаруй хувь нь сумын эмнэлэгт нас барсан дүн гарч байгаа нь сум, багийн түвшинд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж доогуур байгаагаар холбоотой. Эмзэг бүлгийн эхчүүд эндэгдэлд илүү өртөж байна. Хоол тэжээл дутагдсаны улмаас жирэмсэн эхчүүд, хүүхдэд тураал болон цус багадах өвчин их тохиолдож байна.

Хүрээлэн буй орчин, ажил, амьдралын ахуй нөхцөлөөс шалтгаалсан өвчлөл их байна. Хөдөө орон нутагт байгаа эрүүл мэндийн ажилтнуудын мэргэжлийн түвшин харьцангуй доогуур төдийгүй боловсрол мэдлэгээ бийнгэ дээшлүүлэх нөхцөл боломж хомс байна.

Иймд Баруун бүсэд эрүүл мэндийн тогтолцоог боловсронгуй болгох, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг шуурхай, найдвартай хүргэх, эрүүл мэндийн боловсролыг ахиулах шаардлага тулгамдсан асуудлын нэг болж байна.

## Нэгдүгээр үе шат (2006-2010 он):

**Тэргүүлэх зорилт 1.** Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэн хүн ам эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах ая таатай нөхцөлийг бүрдүүлнэ.

### Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

байгаль орчны бохирдлоос сэргийлж, хог хаягдлыг зайлуулах, устгах талаар бүс нутгийн онцлогт тохирсон цогц бодлого боловсруулан хэрэгжүүлэх;

бүс нутгийн хүн амын өвчлэлийн байдлыг тогтоох судалгаа явуулж, эрүүл мэндийн байдлыг хянан тандаж мэдээлэх тогтолцоо бүрдүүлэх;

эрүүл бүс, аймаг, хот, сум, баг болох гэсэн санаачилгыг хөхиүлэн дэмжиж, иргэний нийгмийн нөөцийг дайчлан хувь хүн, хамт олны оролцоог нэмэгдүүлэх;

гэр хорооллыг цэвэр, бохир усны төвлөрсөн системд холбох ажлыг эхлүүлж, айл өрхийг халуун ус, саунтай болгох үүсгэл санаачилгыг хөхиүлэн дэмжих;

бүс нутгийн хүн амын ундны усны чанарыг сайжруулах ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхийн сацуу, рашааны эх үүсвэрийг бүрэн хамгаалалт, хяналтад авах арга хэмжээг хэрэгжүүлэх;

бүсийн болон тулгуур төвийн хотын онцлог, хэтийн төлөвийг харгалзан хот байгуулалтыг төлөвлөхдөө хотын нутаг дэвсгэрийн 10 хувиас доошгүй хэсэгт ногоон байгууламж байгуулах арга хэмжээ авах;

олон улсын хөл хориот өвчнөөс бүсийн хүн амыг хамгаалахад чиглэсэн лаборатори, оношилгоо, эмчилгээний явуулын багийн чадамжийг сайжруулах;

халдварт өвчнийг эсэргүүцэх эм тарилга, вакцины нөөцийг сайжруулах, тусламж, үйлчилгээ хүртэхэд хүндрэлтэй өрхийн хүүхдийн дархлаажуулалтад хамрагдалтыг 95 хувь хүргэж, дархлаажуулалтад хавсарсан вакцин нэвтрүүлэх замаар хатгалтын тоог цөөрүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх;

бүс нутгийн болон нутагшмал эмгэг, эрсдэлтийн хүчин зүйлийг илрүүлэх, сэргийлэх, анагаах арга хэмжээг цогцоор нь авах;

"Эх, хүүхдэд ээлтэй бүс" болох чиглэл баримтлан эх, нялхсын эрүүл мэндийг сайжруулах, эндэгдлийг бууруулах ягтамж заагтай бодлого хэрэгжүүлэх замаар эхийн эндэгдлийг дөрөвний гурваар, нялхсын эндэгдлийг 50 хувь, 5 хүртэлх хүүхдийн нас баралтыг гуравны хоёроор бууруулах;

нэн ядуу, эмзэг бүлгийн хүмүүс, тахир дутуу иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлэх боломжийг нэмэгдүүлэх.

**Гарах үр дүн:** Бүсийн хэмжээнд хүн амын эрүүл мэндэд ээлтэй, аюулгүй орчин нөхцөл бүрдэх үндэс суурь тавигдана.

**Тэргүүлэх зорилт 2.** Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлэхэд чиглэсэн оновчтой тогтолцоо бүрдүүлнэ.

**Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:**

эрүүл мэндийн анхан шатны тусламж, эмнэлгийн дагнасан болон хоршсон тусламж, яаралтай тусламж, уламжлалт эмчилгээ, нөхөн сэргээх болон сувилах эмчилгээг хөгжүүлэх бодлогыг тодорхойлон хэрэгжүүлэх;

Ховд аймаг дахь Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн үйл ажиллагааг чанаржуулахад чиглэсэн цогц арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх;

төвлөрсөн цогц оношилгооны төв, сургалт-эрдэм шинжилгээний бааз, ажиллагсад, суралцагчдын амьдрах орон байр, дэд бүтэцтэй оношилгоо, эмчилгээний цогцолбор төвүүдийг байгуулах;

бус нутгийн хүн амын өвчлөл, нас баралтын зонхилох шалтгааныг илрүүлэх, анагаах технологийн байдалд үнэлгээ өгөх замаар хамгийн зохимжтой технологийг сорчлон нэвтрүүлэх;

эмнэлгийн тусламж, үйлчилгээ хүртэхэд бэрхшээлтэй өрх, хүн амд тусламж, үйлчилгээг хүргэх явуулын үйлчилгээ бий болгох;

эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн ханган нийлүүлэлт, засвар үйлчилгээний төв байгуулах асуудлыг шийдвэрлэх;

алсын зайн оношилгоо, сургалт, зөвлөгөө өгөх мэдээллийн бүсийн сүлжээ байгуулах, эрүүл мэндийн мэргэжилтнийг тогтвор суурьшилтай ажиллуулахад чиглэсэн оновчтой бодлогыг тодорхойлж хэрэгжүүлэх;

өмчийн олон хэвшилд тулгуурласан бүсийн эрүүл мэндийн оновчтой, нэгдсэн тогтолцоо бүрдүүлэх;

нөөцийн (буюу бүтэц), үйл явцын (буюу технологи), үр дүнгийн (буюу төгсгөл) стандартын түвшинд иж бүрэн үнэлгээ хийх замаар эмнэлгийн тусламжийн чанарыг дээшлүүлэх арга замыг тогтоон хэрэгжүүлэх.

**Гарах үр дүн:** Бүсийн хэмжээнд үйлчлүүлэгчид ээлтэй, үр дүнтэй, үр ашигтай, өрсөлдөөн бүхий тогтолцоо бүрдүүлснээр эмнэлгийн тусламж, үйлчилгээний хүртээмж, чанар дээшилнэ.

**Тэргүүлэх зорилт 3.** Эрүүл мэндийн байгууллагын материаллаг бааз, боловсон хүчний хангамжийг сайжруулна.

**Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:**

§ эрүүл мэндийн салбарт зарцуулах санхүүжилтийн эх үүсвэрийг зохисжуулан төсвийн төлөвлөлтийг сайжруулах;

§ “Эм, эмнэлгийн хэрэгслийн хангамжийн сүлжээ” байгуулах, эмнэлгийн суурь технологи хөгжүүлэх боломжийг судалж шийдвэрлэх;

§ хүн эмнэлгийн болон эхчүүдийн амрах байруудыг засварлан тохижуулах, шинээр барих;

§ бүсийн тулгуур төвүүд болон аймгийн төвүүд, бичил бусүүдийн төвд эмнэлгийн тоног төхөөрөмжийг шинэчлэх, нэн шаардлагатай эм, тарианы нөөцтэй болгох арга хэмжээ авах;

§ өрхийн болон сумын эмнэлгүүдийг санхүүжүүлдэг механизмыг боловсронгуй болгож, эмнэлгүүдийг магадлан итгэмжлэлд бүрэн хамруулах;

§ эмнэлгийн боловсон хүчин, эмч, сувилагч нарын мэргэжлийг дээшлүүлэхэд анхаарч, орчин үеийн тоног төхөөрөмжийг эзэмшүүлэх, анагаах ухааны орчин үеийн ололттой танилцуулах сургалт, зөвлөгөөнийг тогтмолжуулах;

§ ажлын байранд нь эмнэлгийн ажилтнуудын мэргэжил дээшлүүлэх нөхцөл бүрдүүлэх;

§ эмнэлгийн мэргэжилтний тоог нэмэгдүүлэх арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх;

§ Говь-Алтай аймгийн Анагаахын коллежийг өргөтгөн их эмч, сувилагчид бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх төв болгон өөрчлөх;

§ эрүүл мэндийн анхан шатны бүртгэл, мэдээллийн компьютержсэн сүлжээний эхлэлийг тавих;

§ хөдөөгийн хүн амын эрүүл мэндийн даатгалын үйлчилгээний хамралтыг нэмэгдүүлэх;

§ сумын түргэн тусламжийн автомашины паркийг жил бүр 15-аас доошгүй хувиар шинэчлэх;

§ бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн тоног төхөөрөмж, мэргэжлийн боловсон хүчний хангамжийн түвшинг дээшлүүлж, өвчтөнийг дагаж ирсэн хүмүүсийг байрлуулах байр барьж, бүсийн бусад аймгуудаас өвчтөн хүлээн авах нөхцөлийг сайжруулах.

**Гарах үр дүн:** Оношилгоо, эмчилгээ, сувилаганы чанарын түвшинг дээшлүүлэх боломж нэмэгдэн, иргэдэд хүрэх хүртээмж сайжирна.

**Хоёрдугаар үе шат (2011-2015 он):**



**Тэргүүлэх зорилт 1.** Эрүүл мэндийн бүх шатны тусламж, үйлчилгээний тогтолцоог төлөвшүүлэн оношилгоо, эмчилгээний хүртээмж, чанарыг сайжруулна.

**Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:**

нийгмийн эрүүл мэндийн үндэсний хөтөлбөрүүдийн уялдаа холбоог сайжруулан эрүүл мэндийн мэдээллийн нэгдсэн сан байгуулах;

§ бүсийн тулгуур төвүүд болон аймгийн төвүүд, бичил бүсүүдийн төвд эмнэлгийн тоног төхөөрөмжийг иж бүрэн шинэчилж, теле-оношилгоо, эмчилгээнд хамрах хүрээг эрс нэмэгдүүлэх;

§ бүс нутгийн хүн амын ундны усны эх үүсвэрийн 90-ээс доошгүй хувьд эрүүл ахуйн хамгаалалтын бүс тогтоож, рашааны эх үүсвэрийг бүрэн хамгаалалт, хяналтад авах;

§ мэдээллийн технологийн ололт дэвшлийг эмнэлгийн тусламж, үйлчилгээнд нэвтрүүлэх чиглэлээр тодорхой төслүүдийг хэрэгжүүлэх;

§ хувийн болон олон нийтийн өмчид суурилсан эмнэлгийн байгууллагуудыг дэмжин хөгжүүлж, оновчтой тогтолцоог бүрдүүлэх.

**Гарах үр дүн:** Эрүүл мэндэд ээлтэй, аюулгүй орчин бүрдэнэ.

**Тэргүүлэх зорилт 2.** Хүн амын нийгмийн эрүүл мэндийг сайжруулах тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглүүлэн эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагуудын материаллаг баазыг бэхжүүлнэ.

**Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:**

§ санхүүгийн нөөцийг зөв зохистой ашиглах, ялангуяа хөрөнгө санхүүгийн эх үүсвэрийг бүрэн дайчлах, оновчтой ашиглах, дэмжлэг авах хөшүүрэг бий болгох;

§ бүсийн тулгуур төвд биеийн тамирын дээд сургууль, бичил бүсийн болон сумдын төвд бялдаржуулах төв байгуулан ажиллуулах;

§ аймгийн болон бүсийн тулгуур төвүүдэд ахмад настанд зориулсан нөхөн сэргээх, асран сувилах газруудын тоог нэмэгдүүлэх;

§ Увс аймгийн Хар тэрмисийн амралт, сувиллын газар, Завхан аймгийн Отгонтэнгэрийн рашаан, Говь-Алтай аймгийн Бигэрийн бөөрний сувиллын газрыг бүсийн чанартай амралт, рашаан сувилал, эмчилгээ, үйлчилгээний газар болгон өргөтгөх;

§ тахир дутуу иргэдэд үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээг өргөтгөж, материаллаг баазыг нь улам бэхжүүлэх;

§ бүсийн тулгуур төв болон аймгийн төв, бичил бүсүүдийн төвийн эмнэлгийн байрыг засварлах, шинээр барих ажлыг эрчимжүүлэх;

§ бүсийн оношилгоо эмчилгээний төвд соронзон томограф ашиглах эрэлт хэрэгцээг судлан шийдвэрлэх.

**Гарах үр дүн:** Өмчийн олон хэвшилд суурилсан эмнэлгийн байгууллагуудын тогтолцоо бүрдэж, хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын түвшин дээшилнэ.

2.6. Хүн амын нутагшилт, хот байгуулалтын талаар

**Үндэслэл:** Баруун бүсийн төв, суурин газруудад бүсийн нийт хүн амын 29.4 хувь нь амьдарч байна. Энэ үзүүлэлт Баян-Өлгийд 30.9 хувь, Говь-Алтайд 32.2 хувь, Завханд 21.4 хувь, Увсад 27.8 хувь, Ховдод 34.4 хувь нь байна. Нийт өрхийн дийлэнх нь эсгий гэрт, үлэмж бага хувь нь орон сууцанд амьдарч байгаа учир орон сууцны асуудлыг шийдвэрлэх нь онцгой чухал ач холбогдолтой байна. Баруун бүсэд хотжилт эрчимтэй бус, үйлдвэрлэл, үйлчилгээ, нийгмийн болон инженерийн дэд бүтэц сул хөгжсөн, барилгажилтын нягтрал бага, нийгэм, соёл, ахуй үйлчилгээний түвшин дорой байна. Бүсийн тулгуур төвүүдэд төдийгүй нийт хот суурингуудад орчин үеийн шаардлагад нийцсэн хот байгуулалтын цэгцтэй бодлого үгүй байна.

Бүсийн хүн амын тархац, нутагшлын жигд биш байдал нь хөгжилд бэрхшээл учруулж байгааг свармагжуулах үүднээс бичил бүсчлэлийг боловсруулан хэрэгжүүлэх шаардлагатай байна.

**Нэгдүгээр үе шат (2006-2010 он):**

**Тэргүүлэх зорилт 1.** Баруун бүсийн хот, суурин газруудын хот төлөвлөлтийг зах зээлийн тогтолцоонд нийцүүлэн шинэ шатанд гаргана.

**Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:**

§ бүсийн тулгуур төв Ховд, Улиастай хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэх;

§ аймгийн төв, бичил бүсийн болон сумдын төвүүдийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг олон нийтийн оролцоотой шинэчлэн боловсруулах ажлыг зохион байгуулах;

§ хил орчмын бүс нутагт хүн ам суурьшуулах зорилго бүхий урамшууллын бодлого хэрэгжүүлж, хүн амын тогтвор суурьшлыг сайжруулах;

§ орон нутгийн нийтийн ахуй, үйлчилгээний байгууллагын менежментийн болон үйлчилгээний чадавхийг бэхжүүлэх;

§ Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын цэвэр усны шугамыг иж бүрэн шинэчлэн, цэвэр усны байгууламжийг сэргээн засварлах;

§ шинээр бий болж байгаа суурин газарт хүн амын төвлөрлийг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлэх;

§ Тосонцэнгэлийн модны үйлдвэрийг түшиглэн Баруун бүсийн барилга, орон сууцны болон гэрийн модон эдлэлийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх;

§ газрын албадыг шинэ техник, технологиор ханган, газрын харилцааны тухай мэдээлэл, бүртгэлийг иргэдэд нээлттэй байлган, үйлчилгээг шуурхай болгож, газрыг айл өрх бүрт үнэгүй өмчлүүлэх ажлыг хуулийн хугацаанд багтаан зохион байгуулах;

§ барилга, хот байгуулалт, газар зохион байгуулалт, газар өмчлөх, эзэмших, ашиглах, үнэлэх болон үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой мэдээллийн нэгдсэн санг аймаг бүрт бий болгох.

**Гарах үр дүн:** Бүсийн төв, хот, суурингуудад хүн амын тогтвор суурьшил нэмэгдэнэ.

**Тэргүүлэх зорилт 2.** Хүн амын өсөлт, орон сууцны хэрэгцээтэй уялдуулан бүсийн орон сууцны хангамжийн түвшинг сайжруулан.

### Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

§ Монгол Улсын Засгийн газрын "40 000 айлын орон сууц" хөтөлбөрийн хүрээнд нийт аймгийн төвд орон сууцны шинэ хороолол барих;

§ "Орон сууц" сан бүрдүүлж, эн тэрүүнд төрийн албан хаагчид, залуу гэр бүлийг орон сууцаар хангах арга хэмжээг хэрэгжүүлэх;

§ орон сууцны барилгын материал үйлдвэрлэж буй аж ахуйн нэгжийг дэмжих;

§ иргэд орон сууцны нөхцөлөө сайжруулах, орон сууцандаа хөрөнгө оруулалт хийх сонирхлыг нь нэмэгдүүлэх;

§ орон гэргүй ядуу өрхийг орон байраар хангах боломжийг судлан хэрэгжүүлж эхлэх;

§ амины орон сууц барьж буй иргэдийг хөнгөлөлттэй зээлээр дэмжих;

§ хөдөөгийн хүн амын орон сууцны нөхцөлийг сайжруулах хөтөлбөр боловсруулан, хэрэгжүүлж эхлэх.

**Гарах үр дүн:** Аймгийн төвүүдийн хүн амын өсөлт, орон сууцны хэрэгцээтэй уялдуулан орон сууцны хангамжийн түвшин 40-50 хувьд хүрнэ.

**Тэргүүлэх зорилт 3.** Бүсийн хөгжлийн хэтийн төлөвтэй уялдуулж бичил бүсээр хөгжүүлэх хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.

### Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

§ бичил бүсийн эрх зүйн орчинг бүрдүүлэх арга хэмжээг идэвхтэй дэмжих;

§ бичил бүсүүдийн биеэ даан хөгжих чадавхийг бүрдүүлж эхлэх;

§ бичил бүсийн хөгжлийн шаардлагатай уялдуулан зам, тээвэр, холбоо, мэдээлэл харилцааны сүлжээ бүрдүүлэх эхлэлийг тавих.

**Гарах үр дүн:** Бүсийн хэмжээнд бичил бүсчлэлийн хөтөлбөрийн дагуу хүн амын нутагшилтын тогтолцоо сайжирна.

Хоёрдугаар үе шат (2011-2015 он):

**Тэргүүлэх зорилт 1.** Баруун бүсийн тулгуур төвүүдийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлж, хөдөөгийн суурингуудыг ерөнхий төлөвлөгөөний дагуу хөгжүүлэх арга хэмжээ авна.

### Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

§ тулгуур төв хотуудыг бүсийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн томоохон төвүүд болгох;

§ зах зээлийн нөхцөлд нийцүүлэн шинэчлэн боловсруулсан хот суурингуудын ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлэх;

§ Говь-Алтай, Завхан, Увс аймгийн төвд нийтийн аж ахуйг сайжруулах арга хэмжээг үргэлжлүүлэн хийж;

§ аймгийн төвийн цэвэрлэх байгууламжид техник, технологийн шинэчлэлт хийж, цэвэрлэгээний түвшинг сайжруулах, бага оврын цэвэрлэх байгууламжийг хэрэглэх арга хэмжээ авах;

§ орон сууцны шинэ хорооллууд байгуулах арга хэмжээ авах;

§ бүсийн үйлдвэрлэл, хэрэглээ, хүн амын өсөлттэй уялдуулан инженерийн шугам сүлжээг өргөтгөн хөгжүүлэх зорилгоор тодорхой төслүүдийг боловсруулан хэрэгжүүлэх;

§ бичил бүсийн төв, сумын төвүүдийг шинэчлэн тохижуулах хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж эхлэх;

§ аймгуудад загвар суурин байгуулж, тохижуулах арга хэмжээ авах.

**Гарах үр дүн:** Бүсийн хүн ам тав тухтай ажиллаж амьдрах нөхцөл бололцоог хангасан, экологид ээлтэй, эдийн засгийн хувьд биеэ даасан, гадаад, дотоод харилцаа сайтай орчин үеийн хот байгуулалт хөгжино.

**Тэргүүлэх зорилт 2.** Хүн амын өсөлт, орон сууцны хэрэгцээтэй уялдуулан бүсийн иргэдийн орон сууцны хангамжийн түвшинг эрс дээшлүүлнэ.

#### Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

§ бүсийн хот, суурингийн бага орлоготой болон залуу гэр бүлийг орон сууцаар хангах дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх;

§ төрийн албан хаагчдад зориулсан орон сууцны хоёр дахь шатны төсөл боловсруулан хэрэгжүүлэх;

§ орон сууцны барилгын материал үйлдвэрлэж буй аж ахуйн нэгжийг татвараас бүрэн чөлөөлөх урамшууллын хөшүүргүүдийг хэрэглэх;

§ орон гэргүй байгаа ядуучуудыг орон байраар хангах цогц арга хэмжээ авах;

§ амины орон сууц барьж буй иргэдийг хөнгөлөлттэй зээлээр идэвхтэй дэмжих.

**Гарах үр дүн:** Аймгийн төвүүдийн орон сууцны хангамжийн түвшинг 50-60 хувьд хүргэснээр хүн амын тав тухтай амьдрах ахуйн нөхцөл сайжирна.

**Тэргүүлэх зорилт 3.** Баруун бүсийн хөгжлийн хэтийн төлөвтэй уялдуулж бичил бүсүүдээр хөгжүүлэх арга хэмжээ авах

#### Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

§ бичил бүсүүдийн хөгжлийн хөтөлбөрийг бүсийн хэмжээнд эрчимтэй хэрэгжүүлэх;

§ бичил бүсийн давуу бөгөмжүүдэд түшиглэн жижиг, дунд үйлдвэр байгуулах, үйлчилгээний салбаруудыг хөгжүүлэх замаар биеэ даан хөгжих нөхцөл бүрдүүлэх;

§ Баруун бүсийн бичил бүс хоорондын дэд бүтцийг зохистой хэлбэрээр бүрдүүлэх;

§ хөдөөгийн иргэд суурин, хагас суурин амьдралд зохицон суурьших боломж бүрдүүлэх.

**Гарах үр дүн:** Бүсийн хэмжээнд хүн амын нутагшилтын оновчтой бүтэц бий болон тогтвор суурьшилтай ажиллаж амьдрах ая таатай нөхцөл бүрдэнэ.

Гурав. Байгалийн нөөцийн ашиглалт, байгаль орчны хамгаалал

#### 3.1. Агаар мандлын хамгаалал

**Үндэслэл:** Баруун бүс нутагт агаар бохирдуулдаггүй өндөр үр ашигтай, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх, бохирдуулагч эх үүсвэрүүдийг цөөлөх, шаталт сайтай зуух, түлшийг өргөн хэрэглэх, хог хаягдлыг дахин боловсруулах, хот, суурин газрыг зүлэгжүүлэх зэрэг ажлыг дэс дараатай хийж, хэвшүүлэх шаардлагатай байна.

#### Нэгдүгээр үе шат (2006-2010 он):

**Тэргүүлэх зорилт 1.** Агаар мандлын чанар, төлөв байдал, уур амьсгалын өөрчлөлтөд тавих хяналт-шинжилгээ, мэдээллийн сүлжээг өргөтгөн, агаарын бохирдол бага байгаа давуу талаа хадгална.

#### Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

§ бүсийн "Агаар" хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх;

§ агаарын бохирдлын түвшин болон бохирдуулагч эх үүсвэрт байнгын хяналт хийж, хотуудын ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн тоног төхөөрөмжийг шинэчлэх;

§ агаар бохирдуулагч эх үүсвэрийн тооллого явуулах;

§ шинээр байгуулах, өргөтгөх, шинэчлэх үйлдвэрлэл, үйлчилгээ болон барилга байгууламжийн төсөлд агаар мандалд нөлөөлөх байдлын үнэлгээ хийж зөвшөөрөл олгох;

§ агаарын бохирдол үүсгэгч байгууллага, аж ахуйн нэгжийг хяналт-шинжилгээнд тогтмол хамруулах;

§ гүйцэд шатдаг гэрийн зуухны технологи, утаагүй түлш нэвтрүүлэх замаар утааг багасгах;

§ авто тээврийн хэрэгснээс гарч буй хорт бодис, угаарын хийн зөвшөөрөгдөх хэмжээ, стандарт мөрдөлтөд тави: мэргэжлийн хяналтын албадын хяналтын үйл ажиллагааг сайжруулж, хот суурингийн замыг цардах, ногоон

байгууламжийг өргөтгөх замаар тоос дэгдэлтийг бууруулах;

§ хил дамжсан агаарын бохирдолтыг хамтран хянах, мэдээлэл солилцох талаар хөрш орнуудын аймаг, муж, хотуудтай хамтран ажиллах;

§ агаар, орчны бохирдлоос урьдчилан сэргийлэх шаардлагатай арга хэмжээний талаархи мэдээллийг сайжруулж, мэдээлэл ашиглах боломжийг нэмэгдүүлэх.

**Гарах үр дүн:** Бүсийн хот, суурин газруудад агаарын бохирдлыг хянах үр нөлөө бүхий тогтолцоо бүрдэн, ялангуяа гэр хорооллын агаарын бохирдлын хэмжээ эрс буурна.

**Тэргүүлэх зорилт 2.** Агаарын бохирдлыг бууруулах тоног төхөөрөмжийн хангамжийг сайжруулж, агаар бохирдуулагчидтай хийх тэмцлийн арга хэлбэрийг боловсронгуй болгоно.

### Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

§ бүсийн аймгуудын шингэн түлштэй цахилгаан станц, уурын зуухуудын тоног төхөөрөмжийг шинэчлэх;

§ сумын төв, суурингийн халаалтын технологийг шинэчлэх;

§ гэр хорооллын айл өрхийн 70 хүртэл хувийг бүрэн шаталттай зуух, түлшээр хангах;

§ гэр хороололд байршилтай ердийн галлагаатай орон сууцнуудыг төвлөрсөн халаалтын системд холбох ажлыг эхлүүлэх;

§ нам даралтын халаалтын зуухаар үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага, аж ахуйн нэгжүүдийг байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд бүрэн хамруулж, аймгийн төвүүдийн 1 дүгээр бүсийн дулаан халаалт, хэрэглэгчдийг төвлөрсөн халаалтын сүлжээнд хамруулах;

§ фреон-11,12-оор ажилладаг хөргөгчийг үйлдвэр, үйлчилгээ, ахуйн хэрэгцээнд ашиглахыг хориглох, хлор агуулаагүй гидрофторт нүүрс төрөгчөөр ажилладаг хөргөгч хэрэглэхийг дэмжих;

§ мэдээлэл, эрчим хүчний салбарт цахилгаан соронзон орны бохирдол багатай технологи нэвтрүүлэх;

§ Баруун бүсийн аймаг, сумын төвүүдийн 1 дүгээр бүсийн цэцэрлэгжүүлэх талбайн хэмжээг 10 хувьд хүргэх;

§ шахмал түлш үйлдвэрлэхэд хувийн хэвшлийн оролцоог бүх талаар дэмжиж, хөрөнгө санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

§ байгаль орчин, хүний эрүүл мэнд, эдийн засагт учруулсан хохирлыг бохирдуулагч нь нөхөн

төлөх, бохирдлыг багасгах зардлыг хариуцах эрх зүйн үндсийг бий болгож мөрдөх;

§ Ховд хотод хог хаягдал ялган боловсруулах бүсийн чанартай үйлдвэр байгуулах.

**Гарах үр дүн:** Агаар мандлыг цэвэр ариун байлгах талаар аж ахуйн нэгж, иргэдийн үүрэг хариуцлага нэмэгдэж, бохирдлын хэмжээ буурна.

### Хоёрдугаар үе шат (2011-2015 он):

**Тэргүүлэх зорилт 1.** Агаарын төлөв байдал, уур амьсгалын өөрчлөлтөд тавих хяналтын хүрээг өргөтгөж, бүсийн мэдээллийн нэгдсэн сүлжээг байгуулна.

### Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

§ агаарын бохирдол, агаарын төлөв байдалд тавих хяналтыг тогтмолжуулж, нарны хэт ягаан туяаг хэмжих багаж, тоног төхөөрөмжийг аймгийн төвүүдэд суурилуулах;

§ сумын төвүүдийн Ус, цаг уур, орчны шинжилгээний салбаруудын 50 хүртэл хувийг агаарын бохирдлын түвшинг хэмжих багаж, тоног төхөөрөмжөөр хангах;

§ эрчим хүчний системийг байгаль орчинд хоргүй тоног төхөөрөмжөөр шинэчлэх, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг ашиглах арга хэмжээг хэрэгжүүлэх;

§ үйлдвэрлэлийн хаягдлыг ашиглан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хаягдалгүй болон дахин боловсруулах техник, технологи нэвтрүүлэх;

§ түлшний шинэ эх үүсгэвэр бий болгох, түүнийг тээвэрлэх, хадгалах, үр ашигтай хэрэглэх талаар дотоод, гадаадын туршлага, санаачилгыг идэвхтэй дэмжих.

**Гарах үр дүн:** Агаарын чанар, төлөв байдал, уур амьсгалын өөрчлөлтөд тавих хяналт сайжирч, бүсийн мэдээллийн сүлжээ бий болно.

**Тэргүүлэх зорилт 2.** Төвлөрсөн суурин газрын агаарын бохирдлыг эрс бууруулах.

### Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

§ төв, суурин газрын айл өрхийн 80 хүртэл хувийг бүрэн шаталттай зуух, түлшээр хангах;

§ гэр хороололд байршилтай ердийн галлагаатай орон сууцнуудыг төвлөрсөн халаалтын системд холбох ажлыг үргэлжлүүлэх;

§ тээврийн хэрэгслээс агаарт гаргах төрөл бүрийн хорт хийг бууруулах зорилгоор аймгийн төвүүдэд "Техник оношилгооны төв" байгуулах;

§ аймгийн төвүүдийн 11 бүсэд хамаарах нам даралтын зуух бүхий үйлдвэрлэл, үйлчилгээний

цэгүүдийг байгаль орчны төлөв байдлын үнэлгээнд хамруулж, боломжтой цэгүүдийг төвлөрсөн халаалтын системд холбох ажлыг дэс дараатай гүйцэтгэх;

§ төв, суурин газрын уур амьсгалыг зөөлрүүлэх зорилгоор аймаг, сумын төвүүдийн 1 дүгээр бүсийн цэцэрлэгжүүлсэн талбайн хэмжээг 30 хувьд хүргэх;

§ шахмал түлш үйлдвэрлэх хувийн хэвшлийн хүрээг улам өргөтгөх;

§ аймгийн төвүүдэд хог хаягдал ялган боловсруулах жижиг, дунд үйлдвэр байгуулах.

**Гарах үр дүн:** Агаар мандлын хамгаалалтын түвшин дэлхийн жишигт ойртоно.

### 3.2. Газрын нөөцийн ашиглалт, хамгаалал

**Үндэслэл:** Монгол орны нийт нутаг дэвсгэрийн дөрөвний нэг гаруй хувийг хамардаг Баруун бүсийн газрын санд хөдөө аж ахуйн болон ойн сан бүхий газар зонхилж, харин бусад зориулалтын газар 3 хүрэхгүй хувийг эзэлж байна. Баруун бүсэд 29 сумыг хамарсан 9607.7 мян.га талбайтай 18 газрыг тусгай хамгаалалтад авсан нь улсын нийт тусгай хамгаалалттай газар нутгийн 45.82 хувь болж байна. Гэвч энэ бус нутагт газрын ашиглалт хамгаалалттай холбоотой шийдвэл зохиох асуудлууд байна. Сүүлийн жилүүдэд малчид худаг устай өвөлжөө, хаваржаа тойрон бөөгнөрсний улмаас бэлчээрийн талхагдал нэмэгдэж, авто тээврийн хэрэгслийн олон салаа зам газрын хөрсийг сүйтгэн бэлчээрийг ихээхэн хомсдуулжээ. Мөн инженерийн хийцтэй худагаа эвдэж сүйтгэсний улмаас их хэмжээний бэлчээрийг ашиглаж чадахгүй хүрчээ. Ашигт малтмал олборлолтой холбоотойгоор хөрсний эвдрэл ихсэх хандлагатай болов.

### Нэгдүгээр үе шат (2006-2010 он):

**Тэргүүлэх зорилт 1.** Газрын нөөцөд экологи-эдийн засгийн үнэлгээ хийж, газрын ашиглалт, хамгаалал, мэдээллийн үйл ажиллагааг сайжруулна.

### Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

§ бүсийн газар ашиглалтын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх;

§ газар ашиглалтын төлөв байдал, үржил шимийг дээшлүүлэх, түүнчлэн стандартын холбогдолтой мэдээ, мэдээллийг иргэдэд хүргэх оновчтой тогтолцоог бий болгох.

**Гарах үр дүн:** Газар ашиглалтыг шинжлэх ухааны үндэстэй сайжруулж ашиглах нөхцөл бүрдэнэ.

**Тэргүүлэх зорилт 2.** Бэлчээрийн талхагдлын хэмжээг 30 хувь, хөрсний эвдрэлд орсон талбайн хэмжээг 10 хувь бууруулж, бэлчээрийн зүй зохистой ашиглалтыг 50 хувь нэмэгдүүлнэ.

### Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

§ мал өсгөх, үүлдэр угсааг сайжруулах зорилтуудыг бэлчээрийн даац, ус, тэжээлийн хангамж зэрэгтэй уялдуулан оновчтой төлөвлөн зохицуулж, арга механизмыг боловсронгуй болгох;

§ бэлчээрийн менежментийг боловсронгуй болгох ажлыг шинжлэх ухааны үндэстэй зохион байгуулах;

§ хөрсийг элэгдэл, эвдрэлээс хамгаалж, цас тогтоох зорилгоор тариалангийн талбайг тойруулан ойн зурвас тарьж ургуулах;

§ тариалангийн эргэлтээс хасагдаж байгаа талбайн хөрсний эвдрэлийг зогсоох, олон наст ургамлын үр тарих, бэлчээрийг нөөцөд шилжүүлэх арга хэмжээ авах;

§ инженерийн хийцтэй уст цэгийг засварлах, шинээр гаргах ажлыг жил бүр хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлж, бэлчээр усжуулалтын түвшинг дээшлүүлэх;

§ үлийн цагаан оготны тархалтыг зогсоох, хор хөнөөлийг багасгах төрөл бүрийн дэвшилтэт арга хэлбэрүүдээс орон нутагт туршиж, сонгон нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэх;

§ тариалан эрхлэгчдэд газрыг өмчлүүлж, түрээслүүлэх зэргээр хөрсний эвдрэлийг бууруулах зохион байгуулалтын цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

§ байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг ашигт малтмалыг ашиглахаас өмнө тогтмол хийлгэж, экологийн хувьд эмзэг газрын нөөцийн ашиглалтыг хязгаарлах арга хэмжээ авах;

§ ашигт малтмал олборлох тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн байгаль орчинд учруулсан сөрөг нөлөөллүүдийг арилгах арга хэмжээ авах.

*(Үргэлжлэл нь дараагийн дугаарт)*

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.  
**Хаяг:** <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвөл.

Улсын Их Хурлын Тамгын газрын  
Хэвлэх хэсэгт хэвлэв.

Улаанбаатар-12  
Төрийн ордон

☎ 265958  
Индекс 14003

☎ 329487  
Хэвлэлийн хуудас 2.5